



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/66

Ховд

Тэргүүний сум, баг, байгууллага
шалгаруулах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Аймгийн шагналын журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газраас сум, баг, байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн дүнгээр шалгарсан нэр бүхий 3 сум, 5 баг, 5 албан байгууллагыг байр эзлүүлснийг хавсралтаар баталсугай.

2. Тэргүүн байр эзэлсэн сум, баг, албан байгууллагын дарга нарыг хавсралтад заасны дагуу үндсэн цалингийн хувиар шагнаж, урамшуулахыг тухайн сум, байгууллагын дарга, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

3. Материалын үнэд зарцуулах 1 284 000 төгрөг (Нэг сая хоёр зуун наян дөрөв)-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



02.00609
D/Zax-A66-Da

СУМ, БАГ БАЙГУУЛЛАГУУДЫН
БАЙР ЭЗЭЛСЭН БАЙДАЛ

2019.01.28

Д/д	Сум, баг, байгууллагын нэр	Эзэлсэн байр	Урамшуулал (хувиар)
Сум			
1	Алтай сум	Тэргүүн байр	100
2	Мөнххайрхан сум	Аймгийн 2018 оны тэргүүний сум	75
3	Мянгад сум	Аймгийн 2018 оны тэргүүний сум	50
Баг			
1	Булган сумын Байтаг баг	Тэргүүн байр	50
2	Алтай сумын Барлаг баг	Аймгийн 2018 оны тэргүүний баг	50
3	Ховд сумын Баянбулаг баг	Аймгийн 2018 оны тэргүүний баг	50
4	Жаргалант сумын Наран баг	Аймгийн 2018 оны тэргүүний баг	50
5	Мөст сумын Давст баг	Аймгийн 2018 оны тэргүүний баг	50
Албан байгууллага			
1	Татварын хэлтэс	Тэргүүн байр	100
2	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	Аймгийн 2018 оны ажлаараа тэргүүлсэн байгууллага, хамт олон	75
3	Эрүүл мэндийн газар	Аймгийн 2018 оны ажлаараа тэргүүлсэн байгууллага, хамт олон	50
4	Боловсрол, соёл урлагийн газар	Аймгийн 2018 оны ажлаараа тэргүүлсэн байгууллага, хамт олон	50
5	Биеийн тамир, спортын газар	Аймгийн 2018 оны ажлаараа тэргүүлсэн байгууллага, хамт олон	50

МАТЕРИАЛЫН ҮНЭ

Д/д	Материалын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Өргөмжлөл	13	80 000	1 040 000
2	Туг	3	38 000	114 000
3	Батламж	13	10 000	130 000
Бүгд үнэ				1 284 000

-оОо-